

“ЛЭНДМН ББСБ” ХК-ИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2021 оны 7 сарын 30-ны өдөр

№ 21/26

Улаанбаатар хот

2021 оны санхүүгийн тайланд аудит хийх хөндлөнгийн аудитын байгууллага сонгох тухай

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.10 дахь заалт, “ЛэндМН ББСБ” ХК (цаашид “Компани”)–ийн дүрмийн 9 дүгээр зүйлийн 9.6.7 дахь заалт, 17 дугаар зүйлийн 17.1 дэх хэсэг, Компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2021 оны 7 сарын 30-ны өдрийн ээлжит хурлын шийдвэрийг тус тус үндэслэн **ТОГТООХ нь:**

1. Компанийн 2021 оны санхүүгийн тайланд хөндлөнгийн аудит хийх байгууллагаар “Эрнст энд Янг Монголия Аудит” ХХК-ийг сонгосугай.
2. “Эрнст энд Янг Монголия Аудит” ХХК-тай байгуулах гэрээний нөхцөлийг хэлэлцэн тохирох, гэрээ байгуулах, гэрээнд гарын үсэг зурах эрхийг Компанийн Гүйцэтгэх захиралд олгосугай.
3. Хөндлөнгийн аудитын байгууллагыг төлөвлөсөн хугацаанд ажиллах нөхцөл, боломжоор хангаж, хамтарч ажиллах, шаардлагатай мэдээлэл, баримт, материалыг гаргаж өгөх, тайланг төлөвлөсөн хугацаанд нийтлэхэд шаардлагатай арга хэмжээг хэрэгжүүлж ажиллахыг Компанийн Гүйцэтгэх захиралд үүрэг болгосугай.



ТУЗ-ИЙН ДАРГА

[Handwritten signature]

ЦОДМАА

“ЛЭНДМН ББСБ” ХК-ИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2021 оны 7 сарын 30-ны өдөр

№ 21/27

Улаанбаатар хот

**Хоёрдогч өглөгөөр өөрийн хөрөнгийг
нэмэгдүүлэх тухай**

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.17, 76.1.18 дэх заалт, 89 дүгээр зүйлийн 89.1 дэх хэсэг, 92 дугаар зүйлийн 92.1 дэх хэсэг, “ЛэндМН ББСБ” ХК (цаашид “Компани”)–ийн дүрмийн 9 дүгээр зүйлийн 9.6.20 дахь заалт, 20 дугаар зүйлийн 20.5 дахь хэсэг, Компанийн Хувьцаа эзэмшигчдийн 2020 оны 3 сарын 28-ны өдрийн ээлжит хурлын 20/04 тоот шийдвэр, Санхүүгийн зохицуулах хорооны Банк бус санхүүгийн байгууллагын үйл ажиллагааны зохицуулалтын журмын 5 дугаар зүйлийн 5.2 дахь хэсэг, Банк бус санхүүгийн байгууллагын үйл ажиллагааны зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг тооцож, хяналт тавих журмын 3 дугаар зүйлийн 3.3.6, 3.5.1 болон 3.5.2 дахь заалт, Компанийн Төлөөлөн удирдах зөвлөл (цаашид “ТУЗ”)–ийн 2021 оны 7 сарын 30-ны өдрийн ээлжит хурлын шийдвэрийг тус тус үндэслэн **ТОГТООХ НЬ:**

1. Компанийн бизнесийн үйл ажиллагааг өргөжүүлэхэд зориулан “АНД Системс” ХХК-аас 2,845,000,000 (хоёр тэрбум найман зуун дөчин таван сая) төгрөгийг хоёрдогч өглөг хэлбэрээр авч, Компанийн хоёрдугаар зэрэглэлийн өөрийн хөрөнгийг нэмэгдүүлэхээр шийдвэрлэсүгэй.
2. “АНД Системс” ХХК-тай байгуулах Хоёрдогч өглөгийн гэрээний нөхцөлийг энэхүү тогтоолын хавсралтаар баталсугай.
3. Энэхүү тогтоолын хавсралтад заасан нөхцөлийн хүрээнд “АНД Системс” ХХК-тай холбогдох гэрээ, хэлцлийг байгуулах, тэдгээрт гарын үсэг зурах эрхийг Компанийн Гүйцэтгэх захиралд олгосугай.
4. Энэхүү тогтоолыг хэрэгжүүлэх, үр дүнг Компанийн ТУЗ-д эргэн тайлагнахыг Компанийн Гүйцэтгэх захиралд даалгасугай.

ТУЗ-ИЙН ГИШҮҮД

	/С.БОРГИЛ/		/Б.ДЭЛГЭРЖАРГАЛ/
	/Ж.ЖАРГАЛСҮРЭН/		/Б.ӨЛЗИЙБАЯР/
	/С.ЭНХ-АМГАЛАН/		/Н.ЦЭВЭГМИД/

ЛЭНДМН ББСБ ХК



УЛААНБААТАР ХОТ
5330751 • 1118267206



“ЛэндМН ББСБ” ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн
2021 оны 7 сарын 30-ны өдрийн ээлжит хурлын
21/27 тоот тогтоолын хавсралт

“АНД СИСТЕМС” ХХК-ТАЙ БАЙГУУЛАХ ХОЁРДОГЧ ӨГЛӨГИЙН ГЭРЭЭНИЙ НӨХЦӨЛ

Хоёрдогч өглөгийн нийт хэмжээ	2,845,000,000 (хоёр тэрбум найман зуун дөчин таван сая) төгрөг
Хүү	14 (арван дөрөв) хувь
Хугацаа	5 (тав) жил
Эргэн төлөх нөхцөл	Хоёрдогч өглөгийн үндсэн өрийг Компанийн банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг хүчингүй болгосон, компани татан буугдсан, дампуурсан, төлбөрийн чадваргүй болсныг зарласан, өөрчлөн байгуулснаас бусад тохиолдолд хугацаанаас өмнө эргэн төлөхгүй.
Хүү төлөх нөхцөл	6 сар тутам
Хувьцаанд хөрвөх нөхцөл	Хоёрдогч өглөгийг хувьцаанд хэрхэн хөрвүүлэх нөхцөлийг Компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлын шийдвэрээр тогтооно.

“ЛЭНДМН ББСБ” ХК-ИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2021 оны 7 сарын 30-ны өдөр

№ 21/28

Улаанбаатар хот

Зөвшөөрөл олгох тухай

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.17, 76.1.18 дэх заалт, 89 дүгээр зүйлийн 89.1 дэх хэсэг, 92 дугаар зүйлийн 92.1 дэх хэсэг, “ЛэндМН ББСБ” ХК (цаашид “Компани”)-ийн дүрмийн 9 дүгээр зүйлийн 9.6.20 дах заалт, 20 дугаар зүйлийн 20.5 дах хэсэг, Компанийн Төлөөлөн удирдах зөвлөл (цаашид “ТУЗ”)-ийн 2021 оны 7 сарын 30-ны өдрийн ээлжит хурлын шийдвэрийг тус тус үндэслэн **ТОГТООХ НЬ:**

1. Компанийн “АНД Системс Тех” ХХК-тай 2017 оны 7 сарын 3-ны өдөр байгуулсан “Үйлчилгээний гэрээ” болон “Зохиогчийн эрх ашиглуулах онцгой эрхийн гэрээ”-д тус тус өөрчлөлт оруулах “Нэмэлт гэрээ”-г “АНД Системс Тех” ХХК болон “АНД Сольюшнс Пти. Лтд” компанитай байгуулахыг зөвшөөрсүгэй.
2. “Нэмэлт гэрээ”-ний нөхцөлийг энэхүү тогтоолын хавсралтаар баталсугай.
3. Энэхүү тогтоолын хавсралтад заасан нөхцөлийн хүрээнд “Нэмэлт гэрээ”, түүний хавсралтуудыг баталгаажуулах, тэдгээрт гарын үсэг зурах эрхийг Компанийн Гүйцэтгэх захиралд олгосугай.
4. Цаашид “Нэмэлт гэрээ” болон түүний хавсралтуудад нэмэлт, өөрчлөлт оруулах талаар хэлцэл хийх, тэдгээрт гарын үсэг зурах эрхийг Компанийн Гүйцэтгэх захиралд олгосугай.
5. Энэхүү тогтоолын хэрэгжилтэд хяналт тавих, хэрэв “Нэмэлт гэрээ”, эсхүл түүний хавсралтуудад нэмэлт, өөрчлөлт оруулсан бол энэ талаар тухай бүр Компанийн ТУЗ-д тайлагнахыг Компанийн Гүйцэтгэх захиралд даалгасугай.

ТУЗ-ИЙН ГИШҮҮД

	ЛЭНДМН ББСБ ХК	
_____/С.БОРГИЛ/		_____/Б.ДЭЛГЭРЖАРГАЛ/
_____/Ж.ЖАРГАЛСҮРЭН/	УЛААНБААТАР ХОТ 118267206	_____/Б.ӨЛЗИЙБАЯР/
_____/С.ЭНХ-АМГАЛАН/		_____/Л.ЦЭВЭГМИД/

“ЛЭНДМН ББСБ” ХК-ИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2021 оны 7 сарын 30-ны өдөр

№ 21/29

Улаанбаатар хот

Гүйцэтгэх захирал чөлөөлөх тухай

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.8 дахь заалт, 83 дугаар зүйлийн 83.15 дахь хэсэг, “ЛэндМН ББСБ” ХК (цаашид “Компани”)–ийн дүрмийн 9 дүгээр зүйлийн 9.6.6 дахь заалт, Компанийн Төлөөлөн удирдах зөвлөл (цаашид “ТУЗ” гэх)–ийн дэргэдэх Засаглал, нэр дэвшүүлэх болон цалин урамшууллын хорооны 2021 оны 7 сарын 30-ны өдрийн ЗХ-21/02 тоот дүгнэлт, Компанийн ТУЗ–ийн 2021 оны 7 сарын 30-ны өдрийн ээлжит хурлын шийдвэрийг тус тус үндэслэн **ТОГТООХ НЬ:**

1. Компанийн Гүйцэтгэх захирал Очирсүрэн овогтой Болдбаатар нь 2021 оны 7 сарын 26-ны өдөр Компанийн Гүйцэтгэх захирлын үүрэгт ажлаас чөлөөлөгдөх хүсэлтээ гаргасан тул энэхүү тогтоол гарсан өдрөөс эхлэн түүний Компанийн Гүйцэтгэх захирлын бүрэн эрхийг дуусгавар болгож, үүрэгт ажлаас нь чөлөөлсүгэй.
2. О.Болдбаатарыг үүрэгт ажлаас нь чөлөөлж байгаатай холбоотойгоор түүнтэй байгуулсан Контрактын гэрээг энэхүү тогтоол гарсан өдрөөс эхлэн дуусгавар болгосугай.
3. О.Болдбаатарт энэхүү тогтоолын хавсралтад заасны дагуу урамшуулал олгохоор шийдвэрлэсүгэй.
4. Компанийн Гүйцэтгэх захирлын ажил, үүргийг хүлээлцэх арга хэмжээг 2021 оны 7 сарын 30-ны өдрөөр тасалбар зохион байгуулж, хүлээн авахыг шинээр томилогдох Компанийн Гүйцэтгэх захиралд даалгасугай.



“ЛЭНДМН ББСБ” ХК-ИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2021 оны 7 сарын 30-ны өдөр

№ 21/30

Улаанбаатар хот

Гүйцэтгэх захирал томилох тухай

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.8 дахь заалт, 83 дугаар зүйлийн 83.1 дэх хэсэг, “ЛэндМН ББСБ” ХК (цаашид “Компани”) -ийн дүрмийн 9 дүгээр зүйлийн 9.6.6 дахь заалт, Компанийн Төлөөлөн удирдах зөвлөл (цаашид “ГУЗ”) -ийн дэргэдэх Засаглал, нэр дэвшүүлэх болон цалин урамшууллын хорооны 2021 оны 7 сарын 30-ны өдрийн ЗХ-21/02 тоот дүгнэлт, Компанийн ГУЗ-ийн 2021 оны 7 сарын 30-ны өдрийн ээлжит хурлын шийдвэрийг тус тус үндэслэн **ТОГТООХ НЬ:**

1. Компанийн Гүйцэтгэх захирлын албан тушаалд Бүлтэн овогтой Удвал (РД: НЮ78072467)-ыг энэхүү тогтоол батлагдсан өдрөөс эхлэн томилсугай.
2. Компанийн Гүйцэтгэх захирлын цалин, урамшууллыг энэхүү тогтоолын хавсралтаар баталсугай.
3. Компанийн Гүйцэтгэх захиралтай Контрактын гэрээ байгуулахыг Компанийн ГУЗ-ийн даргад үүрэг болгосугай.
4. Монгол Улсын Компанийн тухай хууль, Үнэт цаасны зах зээлийн тухай хууль, Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хууль, холбогдох бусад хууль тогтоомж, Компанийн дүрэм, Компанийн ГУЗ-ийн Үйл ажиллагааны журам, компанийн засаглалын журмуудыг чанд баримтлан ажиллахыг Компанийн Гүйцэтгэх захирал (Б.Удвал)-д үүрэг болгосугай.
5. Компанийн Гүйцэтгэх захирал шинээр томилогдсон талаарх мэдээллийг Компанийн болон Монголын хөрөнгийн биржийн цахим хуудсаар дамжуулан олон нийтэд мэдээлэхийг Компанийн ГУЗ-ийн Нарийн бичгийн дарга (Ж.Мөнхцэцэг)-д, холбогдох шийдвэрийг Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн газарт бүртгүүлэхийг Хууль, хянан нийцүүлэлт хариуцсан мэргэжилтэн (М.Нямжав)-д тус тус даалгасугай.



“ЛЭНДМН ББСБ” ХК-ИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2021 оны 7 сарын 30-ны өдөр

№ 21/31

Улаанбаатар хот

Компанийн бүтцийг шинэчлэн батлах тухай

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 7.1.18 дэх заалт, “ЛэндМН ББСБ” ХК (цаашид “Компани”)-ийн дүрмийн 9 дүгээр зүйлийн 9.6.10 дэх заалт, Компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2021 оны 7 сарын 30-ны өдрийн ээлжит хурлын шийдвэрийг тус тус үндэслэн **ТОГТООХ НЬ:**

1. Компанийн бүтэц, зохион байгуулалтыг энэхүү тогтоолын хавсралтаар шинэчлэн баталсугай.
2. Компанийн бүтцийг шинэчлэн баталсантай холбогдуулан Компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2021 оны 2 сарын 5-ны өдрийн 21/07 дугаартай “Компанийн бүтцийг шинэчлэн батлах тухай” тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.
3. Компанийн шинэчлэн батлагдсан бүтцийн хүрээнд үйл ажиллагааг зохион байгуулах, алба, хэлтэс, нэгжийн албан тушаалтныг чиг үүргээр ханган, гүйцэтгэлд хяналт тавьж ажиллахыг Компанийн гүйцэтгэх захиралд үүрэг болгосугай.
4. Компанийн үйл ажиллагаатай уялдуулан зарим хэлтэс, алба, нэгжийн зохион байгуулалт, чиг үүрэгт өөрчлөлт оруулах шаардлагатай тохиолдолд хэлтэс, алба, нэгжийн нэршил, харьяаллыг өөрчлөх эрхийг Компанийн гүйцэтгэх захиралд олгосугай.



“ЛЭНДМН ББСБ” ХК-ИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2021 оны 7 сарын 30-ны өдөр

№ 21/32

Улаанбаатар хот

Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга
чөлөөлөх тухай

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.18 дахь заалт, “ЛэндМН ББСБ” ХК (цаашид “Компани”)-ийн дүрмийн 10.1 дэх хэсэг, Компанийн Төлөөлөн удирдах зөвлөл (ТУЗ)-ийн Үйл ажиллагааны журмын 7.1 дэх хэсэг, Компанийн ТУЗ-ийн дэргэдэх Засаглал, нэр дэвшүүлэх болон цалин урамшууллын хорооны 2021 оны 7 сарын 30-ны өдрийн ЗХ-21/02 тоот дүгнэлт, Компанийн ТУЗ-ийн 2021 оны 7 сарын 30-ны өдрийн ээлжит хурлын шийдвэрийг тус тус үндэслэн **ТОГТООХ НЬ:**

1. Компанийн ТУЗ-ийн дарга Цэвэгжав овогтой Одмаа нь 2021 оны 7 дугаар сарын 26-ны өдөр Компанийн ТУЗ-ийн даргаас чөлөөлөгдөх хүсэлтээ гаргасан тул энэхүү тогтоол батлагдсан өдрөөс эхлэн түүнийг ТУЗ-ийн даргаас чөлөөлсүгэй.

ТУЗ-ИЙН ГИШҮҮД

	/О.БОЛДБААТАР/		/Б.ДЭЛГЭРЖАРГАЛ/
	/В.БАЯРСАЙХАН/		/Ц.ОДМАА/
	/Н.ЦЭВЭГМИД/		/С.ЭНХ-АМГАЛАН/
	/С.БОРГИЛ/		/Ж.ЖАРГАЛСҮРЭН/
	/Б.ӨЛЗИЙБАЯР/		



ЛЭНДМН ББСБ ХК
УЛААНБААТАР ХОТ
5039754 ул.1118267206

“ЛЭНДМН ББСБ” ХК-ИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2021 оны 7 сарын 30-ны өдөр

№ 21/33

Улаанбаатар хот

**Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга
сонгох тухай**

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 78 дугаар зүйлийн 78.1 дэх хэсэг, “ЛэндМН ББСБ” ХК (цаашид “Компани”)-ийн дүрмийн 10.1 дэх хэсэг, Компанийн Төлөөлөн удирдах зөвлөл (цаашид “ТУЗ”)-ийн Үйл ажиллагааны журмын 7.1 дэх хэсэг, Компанийн ТУЗ-ийн дэргэдэх Засаглал, нэр дэвшүүлэх болон цалин урамшууллын хорооны 2021 оны 7 сарын 30-ны өдрийн ЗХ-21/02 тоот дүгнэлт, Компанийн ТУЗ-ийн 2021 оны 7 сарын 30-ны өдрийн ээлжит хурлын шийдвэрийг тус тус үндэслэн **ТОГТООХ НЬ:**

1. Энэхүү тогтоол батлагдсан өдрөөс эхлэн Компанийн ТУЗ-ийн даргаар Очирсүрэн овогтой Болдбаатар (РД:ЙЮ80100817)-ыг сонгосугай.
2. Монгол Улсын Компанийн тухай хууль, Үнэт цаасны зах зээлийн тухай хууль, Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хууль, холбогдох бусад хууль тогтоомж, Компанийн дүрэм, Компанийн ТУЗ-ийн Үйл ажиллагааны журам, компанийн засаглалын журмуудыг чанд баримтлан ажиллахыг Компанийн ТУЗ-ийн дарга (О.Болдбаатар)-д үүрэг болгосугай.
3. Компанийн ТУЗ-ийн дарга шинээр сонгогдсон талаарх мэдээллийг Компанийн болон Монголын хөрөнгийн биржийн цахим хуудсаар дамжуулан олон нийтэд мэдээлэхийг Компанийн ТУЗ-ийн Нарийн бичгийн дарга (Ж.Мөнхцэцэг)-д даалгасугай.

ТУЗ-ИЙН ГИШҮҮД

	/О.БОЛДБААТАР/		/Б.ОДМАА/
	/В.БАЯРСАЙХАН/		/С.ЭНХ-АМГАЛАН/
	/Н.ЦЭВЭГМИД/		/Ж.ЖАРГАЛСҮРЭН/
	/С.БОРГИЛ/		
	/Б.ӨЛЗИЙБАЯР/		



ЛЭНДМН ББСБ ХК
УЛААНБААТАР ХОТ
5039754 № 1118267206